ХУРГАТАЙ ХАЙРХАН

“Хургатай Хайрхан” оюутны тэтгэлэгт хөтөлбөрийн 2026–2027 оны тэтгэлэгт оюутнууд батламжаа гардан авлаа

ХУРГАТАЙ ХАЙРХАН

“Хургатай Хайрхан” ХХК нь орон нутгийн залуусын боловсролд бодит дэмжлэг үзүүлэх, цаашдын чадварлаг боловсон хүчнийг бэлтгэх зорилгоор оюутны тэтгэлэгт хөтөлбөрөө үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

Тус хөтөлбөрөөр 20 оюутанд сургалтын төлбөрийн тэтгэлэг олгодог. Тэтгэлэгт хамрагдсан оюутан сургуулиа төгссөн тохиолдолд түүний оронд шинэ оюутан сонгон шалгаруулж, нийт тэтгэлэг авагчдын тоог 20 хүртэл тогтвортой хадгалдаг. 2025-2026 оны хичээлийн жилд тэтгэлэг авсан оюутнуудаас 5 нь сургуулиа төгссөн тул 2026-2027 оны хичээлийн жилд тэдгээрийн оронд **шинээр 5 оюутан сонгон шалгаруулж, тэтгэлэг олгож байна.**








Хөвсгөл аймгийн Цэцэрлэг, Цагаан-Уул, Бүрэнтогтох сумын оюутнуудаас ирүүлсэн өргөдлийг Компанийн урьдчилан баталсан шалгуур, онооны аргачлалын дагуу Сонгон шалгаруулах комиссын таван гишүүн бие даан үнэлсэн бөгөөд оролцогчдын материал өндөр түвшинд бэлтгэгдсэн байсан тул сонгон шалгаруулалт өрсөлдөөнтэй явагдлаа.

ХУРГАТАЙ ХАЙРХАН


Бид шинээр тэтгэлэгт шалгарсан 5 оюутантай уулзан, тэтгэлэгт хөтөлбөрийн батламжийг гардуулж, хөтөлбөрийн нөхцөл болон цаашид анхаарах зүйлсийн талаар мэдээлэл өглөө.

Тэтгэлэгт оюутнууд маань амжилттай суралцаж, эзэмшсэн мэдлэг, ур чадвараараа **ирээдүйд төрөлх сум, орон нутгийнхаа хөгжилд хувь нэмрээ оруулна** гэдэгт итгэлтэй байна.



Сайн сурч, хийж бүтээх хүсэл эрмэлзэл дүүрэн залуус маань өөрсдийгөө танилцуулж, тэтгэлэгт хамрагдсан сэтгэгдлээ мөн хуваалцлаа.

Ярилцлагыг дараагийн нийтлэлээс танилцаарай.















ХУРГАТАЙ ХАЙРХАН